

Савардан бийгийн ёс уламжлал

Уранчимэгийн Оюундарь 

Соёл урлагийн их сургуулийн Бүжгийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ 2567529457@qq.com

Жамьяндоржийн Эрдэнэхорлоо 

Соёл урлагийн их сургуулийн Бүжгийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Савардан бий нь ойрад монголчуудын дунд эрт үеэс уламжлагдан ирсэн ардын язгуур урлагийн өв бөгөөд бий биелгээний нэгэн чухал салбар, БНХАУ-ын ойрад монголчуудын төлөөлөхүйц биет бус өвийн нэг юм. Тус өгүүлэл нь угсаатны бүжгийг судлах онол арга зүйд тулгуурлан, савардан бийгийн түүх, соёл, нийгэмтэй нь хамтруулан судлах оролдлого хийсэн болно. Савардан зөвхөн бүжгийн хөдөлгөөн бус, харин монголчуудын хүндэтгэлийн ёс заншил, хүмүүжлийн уламжлалыг цогцоор нь илэрхийлдэг. Бийгийн эхэнд гурвантаа сөгдөн мөргөх, насны ялгааг харгалзан өвдөг болон даланд гар хүрч бийг дамжуулах зэрэг дэг ёс нь нийгмийн харилцааг зохицуулах, мөн хүмүүжлийн ач холбогдолтой байжээ. Мөн “яндлах”, “аргамж алдруулах”, “од үзүүлэх” зэрэг торгуулийн зан үйл нь хүн бүрийг бийлж сурахад урамшуулж, өв уламжлалыг бататган үлдээхэд чухал нөлөө үзүүлсэн байна. Иймд савардан бий нь баяр ёслолын урлагийн илэрхийлэл төдий бус, өдөр тутмын амьдрал, ахуй соёл, хүмүүжлийн чухал хэрэгсэл бөгөөд түүнийг цогцоор нь судлан баримтжуулж, бүрэн бүтнээр нь өвлүүлэх нь соёлын дархлааг бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: *Жангар тууль, товшуурын аяс, хүндэтгэлийн ёс, торгуулийн арга*

Traditions of Savardan biy

Oyundari Uranchimeg 

School of Dance Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ 2567529457@qq.com

Erdenekhorloo Jamiyandorj 

School of Dance Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: Savardan biy is a folk art heritage that has been passed down among the Oirad Mongols since ancient times, and is an important branch of dance performance, and one of the representative intangible heritages of the Oirad Mongols of China. Based on the theory and methodology of ethnic dance, this article attempts to integrate savardan with its culture, history, and society. Savardan is not only a dance movement, but also a comprehensive expression of the Mongolians' respectful customs and upbringing traditions. At the beginning of the dance, the rules such as bowing down three times and passing the dance on the knees and the floor, taking into account the age difference, regulated social relations and had educational significance. In addition, the punishment rituals such as “yandlakh”, “argamz alruthu”, and “star show” encouraged everyone to learn to dance and had an important impact on preserving the heritage. Therefore, savardan biy is not only an expression of festive art, but also an important tool for daily life, culture, and education. It is of particular importance to comprehensively study, document, and pass it on in its entirety to strengthen cultural immunity.

Keywords: *Jangar epic, tovshuur tone, etiquette, punishment method*

Оршил

“Савардан” бий бол БНХАУ-ын Шинжаан Уйгурын өөртөө засах орон (ШУӨЗО), ӨМӨЗО-ны Алшаа аймагт оршин суудаг ойрад монголчуудын ардын бүжиг юм. ШУӨЗО-д ойрад монголчууд төвлөрөн суурьшсан байдаг тул савардан бийгийн уламжлал нь нэлээд бүрэн гүйцэд хадгалагдан үлдсэн байна. 2008 онд ШУӨЗО-ны Баянгол мужаас савардан бийг БНХАУ-ын Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлсэн юм. Харин ӨМӨЗО-ны Алшаа аймагт цөөн тооны ойрад монголчууд оршин суудаг учир савардан бийгийн уламжлал нь тасрах хэмжээнд хүрээд байсан боловч дахин сэргээж чадсан байна. Үүний үр дүнд 2021 онд Алшаа аймаг нь савардан бийг ӨМӨЗО-ны Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлж чаджээ.

БНХАУ-ын бүжиг судлаачдын бүтээлд савардангийн талаар бичсэн зүйл цөөнгүй бий. Тухайлбал, “Хятад үндэстний ардын бүжгийн цуглуулга” номд савардангийн хөгжим, хөдөлгөөн, жижиг хэрэглэл, хувцас заслын талаар бичсэн бол Хасуулын “Монгол бүжгийн урлаг” номын “Ойрад монголын савардан хөгжимт бий” хэмээх бүлэгт савардангийн хөдөлгөөнийг дэлгэрэнгүй бичсэн байна. Мөн Пан Май Лингийн бичсэн “Хөгжөөнт наадам - Торгуудын дуу, бүжиг” номд савардан бийгийн гарал үүсэл, төрөл зүйл, шинж чанар, онцлогийг тодруулсан байна. Савардангийн талаар бичсэн зүйлсийг аваад үзэхэд гол төлөв савардангийн төрөл зүйл, хөгжим, хөдөлгөөнд анхаарал хандуулсан нь ажиглагдаж байна. Харин савардан бийгийн ёс уламжлал, зан үйлийн талаар судалсан зүйлс хомс байна.

2015 онд Монгол Улсын СУИС-ийн Бүжгийн урлагийн сургуулийн захирал Ш.Эрдэнэцэцэг тэргүүтэй эрдэмтэн багш нар ШУӨЗО-д савардан бийгийн хээрийн судалгаа хийсэн байна. Тус хээрийн судалгааны үр дүнд “Соёл урлагийн тайлбар толь. Боть V: Бүжиг” (2018) бүтээлд савардангийн талаар 14 толгой үгийн тайлбар оруулсан бол, эрдэмтэн С.Дулам “Шинжааны ойрадын бүжгийн урлаг: Савардангийн түүх домог, утга бэлгэдэл” (2017), Г.Барбаатар “Шинжаан-Уйгарын өөртөө засах орны ойрадуудын бий биелгээ” (2016) өгүүлэл бичиж нийтлүүлжээ.

Судалгааны арга зүй

Язгуур саварданг судалж эх хэрэглэгдэхүүн цуглуулахад хээрийн шинжилгээний арга, биечлэн дагах арга зүй (participant observation) гол арга зүй болсон. Ойрад монголчуудын оршин сууж буй нутаг оронд очиж савардангийн өвлөн уламжлагч нартай биечлэн уулзаж ярилцлага хийж, бүжгийн хөдөлгөөнийг нь ажиглан тэмдэглэж авсан болно. Монгол угсаатны бүжгийн урлагийн онцлог, өвлөн уламжлах арга барил, ёс заншил, утга бэлгэдлийг тодруулахдаа тайлан тайлбарлах (hermeneutics) аргыг ашигласан болно.

Судалгааны үр дүн

Савардан бол домог, дуу, хөгжим, бийгийн хөдөлгөөнийг хослуулсан нийлэг шинжтэй ардын уран бүтээл юм. Савардан бийг товшуур хөгжмийн ая эгшигт бийлдэг онцлогтой. Товшуурын ая данг “товшуурын аяс, савардангийн аяс” гэж нэрлэдэг. Товшуурын аяс нь савардан бийгийн өвөрмөц намба төрх, хөдөлгөөний онцлогийг тодруулж өгдөг бөгөөд үндсэн 12 төрлийн аяс уламжлагдан иржээ. Үүнд, БНХАУ-ын ойрад монголчууд савардан бийлэхэд зөвхөн товшуур хөгжмийн аясад бийлдэг бол Монгол Улсын торгуудууд бий бийлэхдээ товшуур болон шанз хөгжмийн аянд бийлдэг. Энэ нь торгуудын бий буюу савардан нь зөвхөн чавхдах хөгжмийн аясад бийлдэг нь тодорхой харагдаж байдаг. Ойрадуудын товшуурын аясыг дагаж бий бийлдэг талаар “Жангар” туульд ч гардаг юм. Эзэн богд Жангар орд өргөөндөө ард олон, баатруудтайгаа найр хурим хийж, жарган цэнгэж байгааг дүрслэхдээ

“Хоолойн аюуг тааруулж дуулалдаад

Хормойн аюуг тааруулж бийлэлдэн

Цоорын аясыг дагаж дуулалдаад

Товшуурынхаа аясыг дагаж бийлэлдэн...” (Бат 2023, 95) гэж урнаар зураглажээ.

Монгол Улсын ойрад монголчууд “бий бийлнэ” гэдэгтэй нэг адил “савардан бийлнэ” гэж ярьдаг. ШУӨЗО-ны Баянгол монгол үндэстний өөртөө засах мужийн Хээжин Шиан суурингийн товшуурын багш Д.Чулуунбат “Саварданг бийлнэ гэж хэлэх нь зүйтэй. Бүжиглэнэ эсвэл үсэрнэ гэж хэлэхгүй. Бас үсрэх хөдөлгөөн байхгүй. Харин ч нам сууж бийлдэг. Бийлнэ гэдэг үг чинь бие цогцоороо хөдөлгөөн хийнэ гэсэн үг” (Д.Чулуунбат 2024) гэж ярьсан юм. Мөн Тарвагатай аймгийн Ховогсайр монгол өөртөө засах Шиан суурингийн савардан бийч Ч.Төлөмжийг бага байхад нь аав, ээж нь цагаан сараар айл хөршийнхөн, ах дүүсээ гэртээ залаад “Цагааны цай” гэж өгдөг байсан гэнэ. Тэр үеэр ээж нь товшуураа цохихдоо “Төлөй босоод бийл!” гэхэд тэр босоод савардан бийлдэг байсан (Ч.Төлөмж 2024) гэнэ. Савардан нь ойрад монголчуудын ардын бүжиг буюу бий биелгээний нэг төрөл учраас “Савардан бий” гэж нэрлэх мөртөө “Савардан бийлнэ” гэж хэлдэг байна.

Савардан бийг төр хурим, найр наадам, цагаан сар зэрэг баяр ёслолын үед болон ердийн үед ч бийлдэг. Ялангуяа өвлийн шөнийн уртад малаа хотлуулчихаад айл саахалтаараа нэг айлдаа цугларч үлгэр домог ярьж, тууль хайлж, дуу хуур үүсгэн, бийгээ бийлдэг байсан талаар настангууд хуучилдаг билээ. Хүүхэд, хөгшид гэлтгүй нас, хүйс харгалзахгүйгээр бүх хүмүүс бийлдэг бөгөөд хөл муутай хүн хүртэл бийлэхэд зориулсан “Доголон савардан” гэдэг бий байдаг. Энэ нь хүн бүрийн тэгш оролцоог хангахыг эрмэлзсэн хүмүүнлэг ёсны илрэл ажээ.



Зураг 1. Цаваг харж бийлж байгаа хөдөлгөөн. ШУӨЗО-ны Тарвагатай аймгийн Ховогсайр монгол өөртөө засах Шиан суурингийн савардан бийч Ч.Төлөмж. Зургийг: У.Оюундарь 2024.09.08

гурав сөгдөж, гурав мөргөхийн утга учрыг асуухад “Бид өвөг дээдэстээ мөргөх ёстой. Энэ бийг өвөг дээдэс зохиосон уу үгүй юү? Энэ товшуурыг аав чинь зохиосон уу? Энэ бийг би зохиосон уу? Энэ бол өвөг дээдсээс үлдээж өгсөн өв хөрөнгө. Тиймээс энэ товшуурын 12 цохилго, савардан бийг бидэнд өвлүүлж өгсөн өвөг дээдэстээ мөргөх нь хажгаар юу? (таарахгүй юү, тийм биш юү). Эрхээв (эрхбиш) тэд нарт сөгддөг л хэрэг! мөргөдөг л хэрэг!” (Ч.Төлөмж 2024) хэмээн хариулсан гэнэ. Тийнхүү савардан бийлэхдээ өвөг дээдэстээ бийгийн ёс гүйцэтгэж хүндэтгэл дэвшүүлэх ёстой ажээ. Тэрхүү сөгдөж мөргөх ёслолын хөдөлгөөн нь хоёр элементээс бүрдэнэ.

- Тахимдаж суугаад хоёр гараа цээжний өмнө байрлуулж, хоёр мөрөөр урагш, хойш солбиж цохилох аясаар хоёр бугуйгаа ээлжлэн өргөж дарах хөдөлгөөн хийнэ.
- Улмаар гар ташаанд авч мөр урагш, хойш солбиж цохилон бийлэхдээ цээжин биеэр аажмаар бөхийж, зүүн өвдөг газар тавьж сөгдөж мөргөнө. Тус хөдөлгөөнийг гурван удаа давтан хийнэ.

Савардан бийгийн хүндэтгэлийн ёс

Савардан бийлэхдээ өвөг дээдэстээ мөргөж “хүндэтгэлийн ёс” гүйцэтгэдэг байсныг судалгаагаар олж тогтоосон юм. ШУӨЗО-ны Тарвагатай аймгийн Ховогсайр монгол үндэстний өөртөө засах Шиан суурингийн савардан бийч Ч.Төлөмж “Манай энэ савардан бий бол их утга учиртай юм. Өнөөгийн күмүүс (хүмүүс) мэдэж байх биш. Намайг бага байхад манай ээж Цагааны баярт (Цагаан сар) найрын толгой (түрүүнд) дээр нэг дуу дуулчхаад, товшуураа цохиод намайг бийлүүлэхдээ “Дээшээ сайн халиагаад (хараад) мөргө! Цаваг халиагаад бийл гэдэг байсан” (Ч.Төлөмж 2024) хэмээн ярьсан юм. Тийнхүү дээшээ харж, цаваг харж бийлсний дараа “Гурав сөгд, гурав мөргө! гээд мань нарыг гурав мөргүүлээд гурав сөгдүүлдэг” байсан гэнэ. Тэрбээр ээжээсээ



Зураг 2: Сөгдөж мөргөх хөдөлгөөн. ШУӨЗО-ны Тарвагатай аймгийн Ховогсайр монгол өөртөө засах Шиан суурингийн Савардан бийч Ч.Төлөмж Зургийг: У.Оюундарь 2024.09.08.

Гурван удаа сөгдөж мөргөнө гэдэг бол монголчуудын хувьд гүн хүндэтгэл илэрхийлж буйн тэмдэг дохио юм. Эзэн Чингис хаан Бурхан Халдун уулнаа гарч, бүсээ хүзүүндээ тохоод, сөгдөн мөргөсөн тухай “Монголын нууц товчоо”-нд гардаг бол Жангар туулийн олон бүлэгт хаанаа хүндэлж гурвантаа сөгдөж мөргөсөн талаар өгүүлдэг. Монголчуудын төр хуримын ёсонд эхнэр, нөхөр хоёр шагай чөмөг атгаж, шар наранд мөргөдөг төдийгүй бэр болж буй бүсгүй хадам эцгийнхээ гал голомтод гурвантаа сөгдөн мөргөдөг ёс бий.

Савардан бий дамжуулах ёс

Савардан бийг гол төлөв гэрт бийлэх тул ганц нэгээрээ ээлжлэн бийлнэ. Нэг хүн бийлж байгаад товшуурын аяс зогсоогүй байхад дараагийн хүнд бийгээ дамжуулан өгч урина. Үүнд, Шинжааны соёл судлаач Д.Дугаржав өгүүлэлдээ “Ойрадууд савардан бийлэх тусгай хэв журамжсан ёс гуримтай (зүйтэй) байдаг ажээ. Товшуур тоглож савардангийн хөгжим эхлэхэд нэлээд боловсронгуй нэг нь босоод савардан бийлэхэд залж, найр хөөр хөгжөөнтэй болдог” (Дугаржав 2020, 56) хэмээн тэмдэглэсэн байдаг. Иймд бие биедээ дамжуулж ээлж ээлжээр босож бийлдэг учиртай. Савардан бийгийн өвлөн уламжлагч Ч.Төлөмжийн хэлснээр бол нөгөө хүндээ бийгээ дамжуулахдаа мөн л хүндэтгэлийн ёс гүйцэтгэж гурав сөгдөж, гурав мөргөх ёстой ажээ. Төлөмж настан “Биеэсээ бага хүнд (дүү) бийгээ дамжуулахад ч гэсэн гурав сөгдөөд гурав мөргөх юм шүү. Чамаас бага бяцхан боловч тэдэнд бийгийн ёсыг гүйцэтгэх хэрэгтэй. Энэ бол манай монголын хүндэтгэлийн ёсон, савардан бийн хүндэтгэлийн ёсон” (Ч.Төлөмж 2024) гэж онцлон тайлбарласан юм.

Хүндэтгэлийн ёс гүйцэтгэсний дараа бий дамжуулах үйлдэл буюу дохио зангаа хийдэг байна. Шинжааны эрдэмтэн Д.Намжилын “Ойрад монголын зан үйлийн соёл” номонд тэмдэглэснээр “Хөгжмийн цохилго зогссонгүй байдал доор өөр хүнд залгуулахдаа ахмад хүн байвал баруун гараа өвдөгт нь хүрч залдаг, найз буюу дүү байвал баруун даланд нь баруун гараа хүрч залдаг юм” (Намжил 2010, 256) хэмээн нарийн тодорхой тэмдэглэсэн байдаг. Ахмад хүнд бий дамжуулахдаа баруун өвдөгт нь баруун гараа хүргэдэг бол нас чацуу юм уу насаар бага хүнд баруун далан дээр нь баруун гараа тавьдаг байна. Баруун гараараа нөгөө хүндээ хүрч бийгээ дамжуулдаг учир нь монголчууд бусдад юм өгөхдөө зөв гараараа өгдөг, буруу гараар өгөхийг цээрлэдэгтэй холбоотой юм. Төлөмж настны ээж нь “Көгшин күний далыг нь битгий цохиж өг, өвдөгд нь өг! Биеэсээ бага хүнд даланд нь күрж өг! Күүкэд күн көгшин күний далыг нь цохиж болох бишээ!” (Ч.Төлөмж 2024) хэмээн бий дамжуулах ёсыг зааж өгсөн байна. Савардан бийд монголчуудын өвөг дээдсээ шүтэх, ахмад настнаа хүндлэх, нялх балчраа хайрлан хамгаалах ёс уламжлал агуулагдаж байдаг учраас тэрхүү нандин өвөө ёс журмаар нь өвлүүлэн үлдээхийн чухлыг Ч.Төлөмж настан залуу хойчдоо ярьж сургамжилсаар байна.

Савардан бий сургах арга, торгуулийн зан үйл

Ардын бүжиг нь ард түмний амьдралд онцгой үүрэг гүйцэтгэсээр ирсэн учир хойч үедээ сургаж, өвлүүлэн уламжлуулахыг чухалчилсаар иржээ. Ялангуяа эртнээс нааш монголчуудын найр наадам, жаргал цэнгэлийн салшгүй бүрэлдэхүүн нь дуу хуур, бүжиг бий нь болсоор ирсэн бөгөөд ард олон төдийгүй ихэс дээдэс нь тэрхүү өв соёлоо эрхэмлэж байсныг бид “Жангар” туулиас тольдож болно.

“Тавин хоногийн найр наадамд
Бийч хааны хөвгүүд хүүхэд бийлээд
Дууч хааны хөвгүүд хүүхэд дуулаад
Тансаг гэрэл хатан дууд онцлоод

Бурхан цагаан хатан бийд онцлов гэнэ” (Бадмаа 1988, 151) хэмээн гардаг нь хаад, хатад нь өөрсдийн биеэр үлгэрлэж, үр хүүхэддээ дуу, бүжиг сургаж, өв соёлоо өвлүүлж ирсэн эрхэм дээд ёс уламжлал байсныг харуулж байна.

Өвөө, эмээ, аав, ээж нь үр хүүхэд, ач зээ нартаа өвлүүлэн сургадаг гэрийн сургалт савардан бийгийн гол сургалт болсоор иржээ. Эцэг, эхчүүд нь хүүхдүүддээ бага балчраас нь савардан бий сургаж түүгээр дамжуулж монгол урлаг соёлоо сонирхох, хайрлах сэтгэлийг төрүүлдэг байна. ШУӨЗО-ны Баянгол монгол өөртөө засах мужийн Хээжин Шиан суурингийн товшуурын багш Д.Чулуунбат “Бид нарыг бага байхад ээж, аав нар маань биднийг урамшуулж “Савар дин дин цохиж л байна, Хайдан (сайхан) хүүхэн бийлж л байна...” гэж алгаа ташин дуулж, бийлүүлдэг байсан (Д.Чулуунбат 2024)” гээд “Савардан бий бол ойрад монголчуудын ой санамжинд байдаг урлагийн зураглал учраас сайхан бийлж чадахгүй ч гэсэн хүн бүгдийн сэтгэл зүрхэнд оршиж байдаг” гэж ярьсан юм.

Хүүхэд багачуудыг урамшуулж, дэмжиж сургахаас гадна найр наадмын үед муу бийлсэн хүнийг торгож ичээдэг ёс байсан гэнэ. Шинжааны эрдэмтэн Батжав “Эрт үед хурим найр буюу баяр дангар (баяр цэнгэл)-ын үед товшуурч, бийч хүмүүс авьяас чадвараа гайхуулдаг байжээ. Зарим үед бүр мөрийдөн тоглож товшуур эс товшуурдаж чадсан буюу шүүгдсэн хүмүүсийг “яндлах” (яллах), бийлж эс чадсан хүмүүсийг “аргамж алдуулах буюу ханцуйгаар нь од үзүүлэх” мэт хатуу чанга шийтгэл өгдгөөс хүн бүхэн эрхбиш товшуур цохиж, бийлж чаддаг байжээ. Тийм тогтсон даралт шахалт доор хүн бүхэн товшуур болон бийг аяндаа сурч, түүний дотроос нэртэй хүмүүс цолгорон гардаг байжээ” (Батжав 2011, 03) хэмээн бичсэн байна.

Яндлах торгууль: Товшуур тоглож, савардан бийлж чадахгүй хүн, эсвэл мөрийцөөд дийлдсэн хүнийг найрын олны дунд суулгаж торгоно. Үүнд, нэгэн сайн товшуурч “янд” хэмээх аясыг тоглож, нэгэн сайн бийч савардан бийлэнгээ мөнөөх хүнийг зааж:

“А: янд янд юуг нь авна чи?

Б: ясан толгойг нь авна би

А: түүгээр юугаа хийнэ чи?

Б: нохойны идэш хийнэ би

А: янд янд юуг нь авна чи?

Б: хоёр гарыг нь авна би

А: түүнээр юугаа хийнэ чи?

Б: савар хийнэ би

А: янд янд юуг нь авна чи?

Б: хоёр хөлийг нь авна би

А: түүнээр юугаа хийнэ чи?

Б: анжис хийнэ би ...” (Дугаржав 2020, 58) гэх зэргээр асуулт, хариулт маягаар хоорондоо харилцан дуулж биеийн эрхтнийг нь авч элдвийн багаж хэрэгсэл хийнэ гэж шоглон нааддаг зан үйл байжээ.

Аргамж алдруулах: Энэ нь аргамжийн битүү уяасыг уран аргаар тайлахыг хэлж байна. Сайн бийлж чадаагүй хүнийг олны дунд хоёр гарыг нь дэлгэн зогсоож, аргамжийг хоёр давхарлаад, битүү үзүүрийг нь нэг ханцуй дотуур нь оруулж, нөгөө ханцуйгаар нь гаргаад, аргамжийн битүү талд бас нэг аргамж давхарласан, задгай үзүүрийг зангидаж уяад, уясан үзүүрийг нь нэг хүн барьж зогсдог. Торгуулсан хүн аргамжийг тасалж хэрчихгүйгээр уяасыг нь тайлахад аргамж барьсан хүн татаад торгогчийн ханцуйнаас мулталж авдаг. Энэхүү битүү уяасыг тайлж чадалгүй зовж байхад нь товшуурч “янд”-ын аясыг тоглож, бийч савардан бийлж, харилцан янд дуулж ичиж гутруулахын туйлд хүргэдэг байна.

Од үзүүлэх: Од үзүүлэх гэдэг нь савардан сайн бийлж чадахгүй байгаа хүнд дээлийн ханцуйг нь толгойд нь өмсгөж, ханцуйн үзүүрийг нь өөдөө харуулж, од үзэгдэж байна уу? гэж асуугаад ханцуйгаар нь хүйтэн ус асгаж нүүрийг нь норгодог торгуулийн зан үйл юм.

Хүн бүхэн өв соёлоо сурч эзэмшихийг сануулсан дээрх торгуулийн зан үйлүүд нь савардан бий ба товшуур хөгжмийн өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг байжээ.

Хэлэлцүүлэг

Цаг хугацаа, орон зайг даван эрт дээр үеэс өнөөг хүртэл уламжлагдан ирсэн үндэсний соёл, сэтгэлгээний онцлогийг илэрхийлсэн **савардан бийг** хойч үедээ өвлүүлэн үлдээх асуудал нэн чухлаар тавигдаж байна. Харин техник технологийн хөгжил, даяаршлын нөлөөгөөр өнөө цагт үндэсний өв соёлоо хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд тодорхой бэрхшээл тулгарч буй нь үнэн. Иймээс ойрад монголчуудын савардан бийн ёс уламжлалыг гүнзгийрүүлэн судалж, өвлөн уламжлагчдын аман яриа, эх сурвалжийг цуглуулан баримтжуулах нь чухал. Ингэснээр хойч үедээ түүний утга учрыг бүрэн ойлгуулж, өв соёлоо эрхэмлэн өвлүүлэх боломж бүрдэх юм.

Дүгнэлт

Савардан бий нь ойрад монголчуудын дунд эрт дээр үеэс уламжлагдан ирсэн ардын язгуур урлагийн өв бөгөөд бий биелгээний чухал нэгэн салаа мөчир болохын зэрэгцээ БНХАУ-ын ойрад монголчуудын соёлын онцлогийг илэрхийлэх төлөөлөхүйц биет бус өв болжээ.

Савардан бийгийн онцлог нь зөвхөн бүжгийн хөдөлгөөнөөр хязгаарлагдахгүй, харин монголчуудын хүндэтгэлийн ёс заншлыг бүрэн дүүрэн тусгасан өвөрмөц уламжлалд оршдог. Бийгийн эхэнд өвөг дээдэстээ хүндэтгэл үзүүлж гурвантаа сөгдөн мөргөх, бийгээ дамжуулахдаа хүний нас, байр суурийг харгалзан өвдөг болон даланд гар хүрч дамжуулах зэрэг нарийн ёс дэгийг чанд сахидаг нь энэхүү өвийг хүмүүжлийн ач холбогдол бүхий соёлын нандин уламжлал болгож байна. Монголчуудын буруу гараар (зүүн гар) бусдад зүйл өгөхийг цээрлэдэг зан үйлтэй уялдан зөв гараараа бий дамжуулах ёс нь соёлын өвөрмөц дүрслэл болж үлджээ.

Мөн савардан бийгийн уламжлалд багтдаг “яндлах”, “аргамж алдруулах”, “од үзүүлэх” зэрэг хатуу чанга торгуулийн зан үйл нь хүн бүхнийг бийлж сурахыг шаардаж, авьяас чадвараа хөгжүүлэхэд чиглэсэн хүмүүжлийн арга болж ирсэн

байна. Энэ нь савардан бийгийн хадгалалт, өвлөлт, залгамжлалд хүчтэй нөлөө үзүүлж, соёлын тогтвортой байдлыг хангахад чухал түлхэц болжээ.

Савардан нь зөвхөн бүжгийн урлаг төдийгүй, монголчуудын ёс заншил, олон соёлын бэлчир, хүмүүжлийн ач холбогдолтой өвөрмөц хэлбэр мөн гэдгийг батлан харууллаа. Үүнд миний бие ШУӨЗО ба ӨМӨЗО-ы ойрад монголчуудын дунд хоёр удаагийн хээрийн шинжилгээ хийж, ШУӨЗО-ы 13 бийч, 12 товшуурч, ӨМӨЗО-ы 2 бийч, 2 товшуурч, нийт 29 өвлөн уламжлагчтай биечлэн уулзаж аман түүх, товшуурын аяс, бийгийн хөдөлгөөн, ёс уламжлал, зан үйлийг нь баримтжуулж судалгааны эргэлтэд оруулсан болно. Мөн савардан бий нь баяр ёслолын үеэр хийгдэх урлагийн нэг төрөл бус, өдөр тутмын амьдрал, ахуй соёл, хүмүүжлийн практикт чухал байр суурь эзэлдэг өвөрмөц соёлын үзэгдэл юм. Энэхүү үнэт өвийг дуу, хөгжим, домог, хөдөлгөөн, ёс заншилтай нь цогц байдлаар судлан шинжилж, баримтжуулан хадгалж, бүрэн бүтнээр нь хойч үедээ өвлүүлэх нь монголчуудын соёлын дархлааг бэхжүүлэх чухал зорилт мөн.

Талархал: ШУӨЗО-д савардан бийгийн хээрийн судалгаа хийж явахад халуун сэтгэлээр дэмжин тусалсан Баянгол монгол үндэстний өөртөө засах мужийн Хээжин Шиан суурингийн товшуурын багш Д.Чулуунбат, Тарвагатай аймгийн Ховогсайр монгол өөртөө засах Шиан суурингийн “Сахилга бат байцаах хороо”-ны ажилтан Улаанбат, Ховогсайр Шиан суурингийн савардан бийч Ч.Төлөмж, У.Сувсан нарт гүн талархал илэрхийлье.

Ашигласан материалын жагсаалт

- Бадмаа, Д. нар. 1988. *Жангар*. Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.
- Бат, Д. 2023. “*Жангар*” туулийн соёлын хэвшил уламжлал. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Батжав. 2011. *Шинжаан “Өдрийн сонин” монгол хэвлэл*. 2011/03.
- Дугаржав, Д. 2020. “Савардангийн зан үйлийн соёлын шинжийг өгүүлэх нь”, *Өвөр монголын “Нийгэм” сэтгүүл*. 2020/03.
- Доржраа, Ж. 2013. “Жангар жич дуу хөгжим хийгээд бийгийн тухай өгүүлэх нь.” *“Төв Азийн тууль” Олон улсын симпозиум - Их наадам*. Улаанбаатар.
- Намжил, Д. 2010. *Ойрад монголын зан үйлийн соёл*. Үрэмч: Шинжаан ардын хэвлэлийн хороо.

Ярилцлага:

Д.Чулуунбат (Баянгол монгол үндэстний өөртөө засах мужийн Хээжин Шиан суурингийн товшуурын багш, Торгууд ястан, 1977 онд төрсөн)-тай хийсэн ярилцлага. Баянгол монгол үндэстний өөртөө засах мужийн Хээжин Шиан суурин, 2024.09.15).

Ч.Төлөмж (Тарвагатай аймгийн Ховогсайр Шиан сууринд савардан бийч, Торгууд ястан, 1937 онд төрсөн)-тэй хийсэн ярилцлага. Тарвагатай аймгийн Ховогсайр Шиан суурин, 2024.09.08.